



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар ТӨА-2019/17/СТА-ТТЗ - 81/121 Зуунмод

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төв аймгийн Сэргэлэн сумын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 225 иргэн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө борлуулсны орлогын албан татварын 24,848.9 төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.11 "газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна", 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 -д "... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", МУЕА-ын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12 бүлгийн аудит хийх үе шатны 12.11-д "аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг залруулах боломж байгаа эсэхийг эхэлж шийдвэрлэх бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийн шинж байдлаас нь хамааран дараах шийдвэрүүдийн аль нэг хэлбэрээр эцэслэн шийдвэрлэж баримтжуулан баталгаажуулна" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Тайлант онд 225 иргэн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө борлуулсны орлогын албан татварын 24,848.9 төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019.06.25-ны дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэргэлэн сумын засаг дарга Э.Энхбаяр, газрын даамал Б.Ууганцэцэг, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Отгонхуяг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

<b>ӨГСӨН<sup>2</sup>:</b>		<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ц.ХИШИГЖАРГАЛ	ЗАСАГ ДАРГА	Э.ЭНХБАЯР
АХЛАХ АУДИТОР	Ц.БАЗАРСАД	САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ	С.ОТГОНХУЯГ

<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцгач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.